Лувсанчойдог маарамбын бичсэн анагаах ухааны эртний судар дахь эрдэнийн эмийг тайлбарлахуй

Б.Чимэг[1,3], Л.Тэрбиш[2], Ш.Болд[1]

[1]АШУҮИС
[2]МҮШУА
[3]Монгол анагаах ухааны коллеж, ӨМҮИС
Цахим шуудан: bold@mnums.edu.mn, Утас: 99111418

Түлхүүр үг:

Дармо маарамба
Гар бичмэл
Судар
Уламжлалт анагаах ухаан

Товч утга:

Үндэслэл: Эрдэнийн эмийн найрлага бол бусад амарлиулах эм найрлагаас хүч их, өвчнийг дахин хөдөлгөхгүй, үндсээс нь дарж чаддаг онцлогтой тул бусад амарлиулах найрлагаар засаад мухардсан өвчнийг анагаах ба өвчний урхагийг гаргахад хэрэглэдэг. Эрдэнийн эмийн найрлагын өвчин анагаах хүрээ өргөн байдаг. Эдгээр зохиолуудаас гадна ойрын хэдэн жилд үмэ (dbu med) буюу толгойгүй үсгээр өөрөөр хэлбэл бичмэл төвөдөөр бичсэн эрдэнийн эмийн талаар өгүүлсэн хэд хэдэн судар олдсон ч унших, орчуулах боломж муутай, огт судлагдаагүй байсаар байна[3]. **Зорилго:** Дармо маарамба Лувсанчойдогийн “Сайн номлол цагаан лянхуан эрхи хэмээх оршвой” гар бичмэл сударт буй эрдэнийн эмтэй холбоотой үгийг дэлгэрэнгүй тайлбарлах, өнөө цагийн хэллэг, бичлэгт ойртуулах, эдүгээчлэх зорилго тавив. Арга, аргачлал: Эх бичгийн судалгааны аргыг хэрэглэн задлан шинжилсэн үр дүндээ олон талын шинжилгээ, тайлбар, үнэлэлт дүгнэлт хийж, нэгтгэн дүгнэж улмаар шинэлэг тал, онцлог, ач холбогдлыг тайлбарлан тодорхойлов. **Үр дүн:** Бид Дармо маарамбын “Сайн номлол цагаан лянхуан эрхи хэмээх оршвой” (legs bshad be ed’u dkar po’i ‘phreng ba zhes bya ba bzhugs so) толгойгүй хорхой шар үсгээр бичсэн гар бичмэл судрын эх бичгийн судалгааг эх бичиг судлалын өнөөгийн төвшинд аль болох ойртуулахыг чармайн тус судрын дотор байгаа эрдэнийн зүйлийн онцлог, галиг, тайлбар, харьцуулалт, хөрвүүлэг зэргийг нэгэн дор хамтатган судлав.[4,5] **Дүгнэлт:** Дармо маарамба Лувсанчойдогийн “Сайн номлол цагаан лянхуан эрхи хэмээх оршвой” гар бичмэл судар нь олон эрдэнийн эмийн эх булгийг шинжлэх арга, эмийн гол судруудад байгаа эрдэнийн эмийг хялбар таних, ойлгуулах, тэдгээрийн ангилал, агуулга, нэр томьёог сайтар тайлбарласан улаан хөтөлбөр болсон бүтээл болох нь судалгаагаар тогтоогдов.

Үндэслэл: Эрдэнийн эмийн найрлага бол бусад амарлиулах эм найрлагаас хүч их, өвчнийг дахин хөдөлгөхгүй, үндсээс нь дарж чаддаг онцлогтой тул бусад амарлиулах найрлагаар засаад мухардсан өвчнийг анагаах ба өвчний урхагийг гаргахад хэрэглэдэг. Эрдэнийн эмийн найрлагын өвчин анагаах хүрээ өргөн байдаг. Хий, шар, бадган, цуснаас болсон, шарх, усан хаван, суваг хаван, чихиха, сахуу, боом зэрэг нянтай өвчин, мэдрэлийн өвчин, уяман өвчин, шар усны өвчин зэргийг анагаахын зэрэгцээ эрүүл хүнд шимжүүлгээр хэрэглэж болно.

Дармо маарамба Лувсанчойдогийн бичсэн “Увдисын үндэс”-ийн тайлбар “Алтан чимэг”, “Язгуурын үндэс” болон “Онолын үндэс”-ийн тайлбар “Алтан хадмал”, “Хойд үндэс”-ийн тайлбар “Бэрх оньсны очир зангилааг тайлагч”, “Зарлигийн эрхэст харанхуйг арилгагч зул”, ховор чухаг эмчилгээний арга, нууц увдисыг багтаасан “Анагаах ухааны битүүмжит увдис” гэх мэт зохиол бүтээлүүд нь Монгол анагаах ухааны онол, эмчилгээ, сургалт, судалгааны ач холбогдолтой сурвалж бичиг болсоор иржээ[1,2]. Эдгээр зохиолуудаас гадна ойрын хэдэн жилд үмэ (dbu med) буюу толгойгүй үсгээр өөрөөр хэлбэл бичмэл төвөдөөр бичсэн эрдэнийн эмийн талаар өгүүлсэн хэд хэдэн судар олдсон ч унших, орчуулах боломж муутай, огт судлагдаагүй байсаар байна[3]. Иймд бид Дармо маарамба Лувсанчойдогийн анагаах ухааны бичмэл судруудыг судалгаа, сургалтад

ашиглах боломжийг бүрдүүлэх, ялангуяа эрдэнийн эм тус бүрийг нарийвчлан тайлбарлах, тайлал хийхээр энэхүү сэдвийг сонгон авлаа.

Зорилго: Дармо маарамба Лувсанчойдогийн "Сайн номлол цагаан лянхуан эрхи хэмээх оршвой" гар бичмэл сударт буй эрдэнийн эмтэй холбоотой үгийг дэлгэрэнгүй тайлбарлах, өнөө цагийн хэллэг, бичлэгт ойртуулах, эдүгээчлэх зорилго тавив.

Арга, аргачлал:
1. Эх бичгийн судлалын арга: Эх бичгийн судалгааны аргыг хэрэглэн эх бичиг судлалын өнөөгийн түвшинд аль болох ойртуулахыг чармайн Дармо маарамба Лувсанчойдогийн гар бичмэл бүтээлийн тойм, уг эх, нэр, газар орон, гол онцлог, агуулга, эх хэрэглэгдэхүүн, галиг, тайлбар, харьцуулалт, хөрвүүлэг зэргийг нэгэн дор хамтатган судлав.
2. Анализ, синтезийн арга: Энэ аргыг ашиглан судалж судрыг бүхэлд нь задлан шинжлэв. Мөн задлан шинжилсэн үр дүндээ олон талын шинжилгээ, тайлбар, үнэлэлт дүгнэлт хийж, нэгтгэн дүгнэж улмаар шинэлэг тал, онцлог, ач холбогдлыг тайлбарлан тодорхойлов.

Үр дүн: Бид Дармо маарамбын "Сайн номлол цагаан лянхуан эрхи хэмээх оршвой" (legs bshad be ed'u dkar po'i 'phreng ba zhes bya ba bzhugs so) толгойгүй хорхой шар үсгээр бичсэн гар бичмэл судрын эх бичгийн судалгааг эх бичиг судлалын өнөөгийн төвшинд аль болох ойртуулахыг чармайн тус судрын дотор байгаа эрдэнийн зүйлийн онцлог, галиг, тайлбар, харьцуулалт, хөрвүүлэг зэргийг нэгэн дор хамтатган судлав [4,5].

Эрдэнийн эмийн аймаг: Эрдэнийн эмийн эмийг 1. Эс хайлагдах эрдэнийн эм, 2. Хайлагдах эрдэнийн эм гэж 2 хуваадаг. Эрдэнийн эмийн чадлыг хураангуйлбал: "Алт нь урт наслуулж, хөгшдийг чийрэгжүүлж, эрдэнийн хорыг арилгана. Мөнгө нь шар ус, өгөр, цусыг хатаана. Зэс нь өгрийг хатааж уушги, элэгний халууныг арилгана. Төмөр нь элэгний хор нүдний өвчин, хаванг арилгана. Оюу нь хорын халуун, элэгний халууныг арилгана. Сувд тархи гарахыг тогтоох, хорын өвчнийг арилгана. Хясааны чадал сувдаас ялгаагүй байдаг. Лавай нь өгрийг хатааж, цугласныг гаргаж, ясны халууныг арилгана. Шүр нь элэг, судлын халууныг, хорын халууныг арилгана. Номин нь хор, шар ус, хулгана, ярыг арилгана" гэжээ[6]. Дармо маарамба дээрх эрдэнийн эмийн чадал, үйлдлийг улам нарийсган, зарим зүйл төрлийг нэмж өгүүлсэн байна. Тэрбээр:

Эрдэнэ тэргүүтний сайн, мууг мэдсэн ч

Эрхэм шашдир бус, тэр үгүйд ч бус хэмээн зарлигласан мэт гурван газар Энэтхэг, Нангиад, Монгол тэргүүтний адил үгүй их эрдэнийн язгуурт эдгээрт туслах сийрүүлгийг зохиосон нь тэр ч эрдэнэ бүхний эрхэм нь түүнчлэн ажирсныг ринсрэл[1] хэмээнэ гээд ринсэл гэдэг эрдэнийг дээд болгон эхэлж дурджээ.

1. Ринсэл: Үүнийг лагшны шарилын ринсрэл (ring srel), лагшин унгарилын ринсрэл[2] хийгээд гичийн үр мэт ринсрэл, номын лагшны ринсрэл дөрөв зүйл байна.

Юуны өмнө лагшны шарилын ринсрэл нь шарам (sha ram) хэмээх дуунаас эвдлэн сүйтгэхүйгээс хагацсан бат бэх хатуу очир лагшны шарилыг найман хувьд хуваасны нэгэн болно. Лагшны шарилын найман хувийн домог нь бусдад тодорхой ба Мажэйда хаан (rgyal po ma skyes dgra)-ы хувьт бурхны лагшны шарил нь Төвөдөд буй бөгөөд тахианы өндөг төдий хэмжээтэй хэмээн алдаршив (Зураг 1).



Зураг 1. Лагшны шарилын ринсрэл

Хоёрдугаарт, лагшин унгарилын ринсрэл нь тэргүүний үснэр хийгээд хумс тэргүүтэн ба гуравдугаарх нь өнөө маргаашийн ринсрэл хэмээн алдаршсан энэ бөлгөө. Их нь тахианы өндөг төдий ба дунд нь хятад буурцаг төдий өчүүхэн нь цагаан гич төдий болой. Чухамдаа Буддын гэгээнтнүүдийг чандарлахад гэгээрлийнх нь төвшнөөс хамаарч ринсрэл гэх сувдан хэлбэртэй талст үлддэг. Тун ч ариун нандин зүйл, заримдаа сургаал номлолоос ч чухал байдаг. Сувдан хэлбэртэйгээс гадна шүд, ясны ринсэлүүд байдаг. Ринсрэлийг харсанаар асрал энэрлийн сэтгэл төрдөг учиртай.

Эрт цагт бурхны ном бөхөхүй цагт түүнчлэн ажирсны ринсрэл нүгүүд эрдэнийн дүрсэнд хувирч, жич дээдийн номын номхотгохуй зохистой хэрэгт таван өнгөт нүд мэт долоо буй. Түүнийг огторгуй уруу харахуйд өдөр одод харагдан, олон зүйлийн бөс давхарлан тавьсны доор тавьсан ч үнэнийг өгүүлбээс дээр нь гарах нэгэн бөлгөө. Энэ эрдэнийн үнэ нь үнэлшгүй бөлгөө.

2. Биндэрьяа: Биндэрьяа (Aqua marina) нь цагаан хийгээд шар, хөх гурван зүйл буйгаас цагаан нь түүнчлэн ажирсны ринсрэлээс гарсан хэмээн "Судрын аймаг цагаан лянхуа"-гаас номлосон буй. Латинаар aqua marina гэнэ. Мөн чанар нь усны өнгөтэй маш тунгалаг огторгуйн өнгөөр урвахуй эрдэнэ хэмээсэн тэр ямагт болой. (Зураг 2)

[1] Ринсрэл (རིན་སྲེལ།) нь ихэс дээдсийн шарилыг дэгдээхэд гарах эрдэнийн үрэл хэмээн алдаршив.
[2] Лагшин унгарилын ринсрэл (སྐུ་བལ་གྱི་རིན་སྲེལ།) нь бурхан буюу бодисадва, язгуурын лам нарын үс, хумс, хувцас навс тэргүүтний ринсрэл болно.



Зураг 2. Хөх биндэрьяа (Aqua marina)

Шар биндэрьяа нь муурын нүд мэт шар ба шимиг (zhi mig) хэмээхүй дотроо гурван утас нийтгэн хийсэн мэт харагдах бөгөөд галд түлвэл үлэмж их гэрэл гардаг болой. Хөх биндэрьяа нь хувилан төрсөн гардиуд далайн доторх могойн дүрсийг идсэний хүчээр өөрийн биеийг галд түлсэний шим бөгөөд мөн чанар нь их хүмүүний гуяны төдий хэмжээтэй, найман талтай, шөнө зуун бээрийн газар гэрэл гаргадаг, нарны халуунд найман гишүүн төгс, сэрүүн ус буулган, найман бээрийн газрын эргэн тойрноо өвчин эмгэггүй болгодог.

Энэ эрдэнэ ямагт индранил тэргүүтэнтэй эс эндүүрэхийн ялгамж нь өчүүхэн төдий ногоон, шөнө магад үгүй гэрэл гаргана. Биндэрьяан гэрлийг хадгалснаар өвчин бүхнийг арилгана хэмээн номложээ.

3. Бадмааараг: Бадмааараг (Rubinus) нь улаан өнгөтэй гурван зүйл. Ягаан, хүрэн улаан, шунхны өнгө мэт гурван зүйл буйгаас дундах хүрэн улааныг нэл (nel) хэмээдэг (Зураг 3). Зэргээр ялгавал сүүлийнх нь сайн болой. Үүнийг дэлгэрүүлвээс гурван зүйлээс өнгө нь ангир улаан шар гэрэл гаргадаг бадмааараг хийгээд тохой хэр хэмжээтэй, үүлэн улаан өнгийн гэрэл тасралтгүй гаргадаг нь задирага (dzatiraga) хийгээд болсон анар өнгөтэй дугариг гэрэл цацруулдаг нь мүхарага (mukhara) хийгээд сүүлчийнх нь газарт тавьбал гэрэл эс гарган, хүрэлцвээс гэрэл гаргадаг нь гүмида (dgumirda) зэрэг болой. Үнэ нь сайн нь алтыг гучаар өсгөсөн мэт болой. Бадмааргаар өвчин хийгээд ад бүхнийг булаамуй хэмээн номложээ[7].



Зураг 3. Шунхан улаан бадмааараг (Rubinus)

4. Индранил: Индранил (Sapphirus) хэмээх хөх их эрдэнийн чулуу 3 зүйл байдаг бөгөөд нила (n'ila), гаганила (ka kan'ila), индранила (indranila) лугаа гурав болой. Анхны нила нь цайвар хөх байдалтай, шар төдий туяатай хөх гэрэл гаргадаг. Хоёрдугаарх гаганила нь хар хөх байдалтай, нарны зүгт харуулахад гэрэл гаргах болой. Гуравдугаарх нь индранила нь хөх гэрэл гаргах дээд нь болох буй. Үүний дээгүүр бөс даавуугаар бүтээхэд шүхэр мэт хөх гэрэл гардаг. Үүнийг Сингал орны Бадмаганга мөрнөөс гардаг хэмээн үздэг. Үнэ нь зэргэмжээр зуун алт хийгээд арван алт тэргүүтний үнэтэй хэмээн номлосон болой. Индранилаар өвчин бүхнийг хоцроолгүй арилгана хэмээн номложээ.(Зураг 4)



Зураг 4. Хөх их эрдэнийн чулуу индранил (Sapphirus)

5. Маргад: Маргад (Smaragdus) хэмээх ногоон эрдэнэ гурван зүйл бөгөөд шо маргад (sho markatta) хийгээд рагда маргада (rakta markatta) хийгээд нила маргад (n'ila markatta) хэмээх гурван зүйл гэж номлов (Зураг 5). Маргад эрдэнэ өвчин бүхэнд дээд тустай хэмээн номложээ.



Зураг 5. Маргад (Smaragdus)

6. Алмаас: Эрдэнийн эрхэм очир алмаас (Diamond) нь базрахира (badzrahira) хэмээх хоёр зүйл очир алмаас бөгөөд газраас гардгийг нь их очир алмааз, уснаас гардгийг нь өчүүхэн алмаас гэнэ. Анхдугаар нь Додгири (bdodgiri)-гээс гарна. Их, бага нь ямар мэт байдаг ч хэлбэр нь арвай буюу тутарга мэт, бөглүү газрын чулуу мэт, болжморын өндөгний хэлбэртэй ч гардаг хэмээдэг. Заримдаа чулуун болор мөн хэмээн алдаршсан болой. Үүнийг нүдвээс эс эвдрэх, таславаас эс тасрах, түлэвээс эс түлэгдэх, үрвээс эс үрэгдэх дөрвөн эрдэм төгс. Таслан, нүхэлж чадах болой. Мөн, бусыг шинжлэх нь өөр эрдэнийн хажууд чирвээс зураг гарвал дээд хийгээд гулган эс үйлдэн өчүүхэн төдий баригдвал эгэл, зураг юу ч эс гарвал олонх алмаас бус

хэмээн магадлана. Үүнд залбирал талбиваас дээд талд гал бадран, доод талаас ус буух тэргүүтэн хүссэн бүхэн гарах бөлгөө. Тэр ч эрдэнийн эрхэм очир алмаас бөгөөд энэ нь далайгаас гардаг хэмээн сонсов. Өчүүхэн төдий тунгалаг бээр холоос харахад нарны гэрэл тусах цагт сувд мэт. Их, бага нь магадлал үгүй элдэв янз гармуй. Тэр ямагт өнөө, маргааш Дээд Монголоос гарсан үзэгддэг болой. Алмаас мөн, бусыг шинжлэх нь зөөлөн болорын талд чирвээс зураг гарвал маш сайн бөгөөд гулган эс үйлдэн өчүүхэн төдий баригдвал муу, энэ нь эрдэнэ бүхний эрхэм мөн. Үүгээр эс эвдрэх эрдэнэ алин ч үгүй. Биедээ зүүвээс лусын хорлолуудыг арилгана хэмээн зарлигласан болой. Уснаас гарсан алмаас нь галаар эвдрэх ч чадал өмнөх бусад лугаа ялгамж үгүй болой. Алмаасын чадлаар аянгыг хариулан үйлдмүй хэмээн номложээ. (Зураг 6)



Зураг 6. Очир алмаас (Diamond)

7. Шүр: "Цагаан лянхуан баглаа" номонд: "Шүр нь далайн хөвөөнд гол модны мөчир, гишүүн мэтээр ургаж, үзүүр нь наранд боловсорч улайх ба үндэс нь элсэнд хучигдсаар цагаан болно" хэмээн номложээ. Латинаар corallium гэдэг. Үүгээр элэг, судасны халуун, хорын халууныг арилгана. Хүн төрөлхтөн эрт дээр үеэс шүрийг муу муухайгаас хамгаалах ариун сахиус болгон хэрэглэж, тахин шүтэж ирсэн. (Зураг 7)



Зураг 7. Шүр (Corallium)

Шүр орсон гол жорыг Шүр-25 гэдэг. Цусны даралт ихэссэнээс үүдэлтэй толгой өвдөх, толгой хүчтэй хатгаж өвдөх, дагзаар хөших, нүүр саажих, мөчүүд хөших, агших, мөчний мэдээ алдах, бадайрах, салганах, татах, тал бие саажих, судасны цус бөглөрөх (зогсонгиших), түгжрэх, цусны эргэлт муудах, унаж татах, мэдрэлийн болон судасны үрэвсэл, суудлын мэдрэлийн өвчин, тархиар хатгаж өвдөх, мэдрэл саажих, алдагдах, тулай өвчин, үений үрэвсэл зэрэгт ууж хэрэглэнэ. Эрүүл хүн дээрх өвчнөөс сэргийлэх зорилгоор хэрэглэж болно[8].

8. Сувд: Сувдыг (Margaritae) гарди шувууны бөөлжис чүнжиг (khyung skyugs) гэдэг. Далайн захад лус могойн дүрсэнд оргоносныг идэж, жич бөөлжсөнд чүнжүг буюу гардийн бөөлжис хэмээсэн гэдэг. Язгуур нь тав буй хэмээн номлосон бөгөөд цагаан лугаа адил ба шар нь хув мэт, хар ногоон нь эрдэнэ адил, цайвар шар хийгээд цайвар ногоон нь өмнө номлосон мөн болой. Үүнийг мөн бусыг шинжлэн үйлдэхэд гичийг чулуунд үрээд, түүний дээр чүнжүгийг үрэхэд улаан шар хунд мэт болбоос сайн, өчүүхэн төдий улаан нь муу мөн болой. (Зураг 8)



Зураг 8. Сувд (Margaritae)

Нарны галт шил хэмээн алдаршсан нарны гэрэл лүгээ учирсан даруйд өөрийн гэрдээс[3] бус эс гарах ба зандраганди (tsanra kanti) хэмээх саран усан болор хэмээн алдаршсан арван тавны сарны гэрэл лүгээ учирсан даруйд өөрийн гэрлээс ус гардаг бөгөөд энэ ямагт маш ховорхон бөлгөө. Мөн Нангиадаас гарсан долзам (dkrol tsam) хэмээх наран лугаа учраваас гал гаран, саран лугаа учраваас ус гардаг, өнгө нь ногоон шар буй болой. Жич хуучны болорын язгуур хар ногоон эрдэнэ хэмээгч наршэл (brnar shel)-ийн байдалт энэ ямагт нь эрдэнэ хэмээн алдаршсан болой. Сувданд таван зүйл буй бөгөөд ганза сувд (gandza mutig), валү сувд (walu mutig), рамба сувд (rampa mutig), бадам сувд (padma mutig), виши сувд (bishi mutig) лугаа тав болой. Чулуунаас гарсан эрдэнэ хуучин оюу бөгөөд зургаан цагаан, зургаан улаан, арилсан оюу хэмээн гуравт таалдаг. Цагаан нь их зургаан цагаан бэсрэг хэмээгч нь адыг сахихуйн дээд мөн болой. Лигвүмиг[4] долоо, тав, гурав, цайвар хүжийн зурагт цайвар шар, алаг, хар тэргүүтэн олон буйн дээд дээдэх нүгүүдийн дээдээр адыг сахихад сайн. Үнэт эрдэнэ лигбүмиг хэмээхийг хүсэх болбоос өнөө маргааш Хам (Хуучин төвөдийн нэгэн муж) хэмээх орноос гарсан байх бөлгөө. Үүгээр тархи цувирахыг зогсоох ба хорын өвчнийг арилгана.

Сувд орсон гол жор Сувд-25 нь тархины харвалт, саа, саажилт, нүүрний саа, мэдрэхүй алдагдах ялангуяа хөдөлж, явахад бэрх болох, үе гишүүн

[3] Гэрэл гэсэн утгатай үг.

[4] Лигвүмиг нь тогос чулуу, чулуун ногооц, тунсаа хэмээн эмийн сударт тэмдэглэгдсэн

хөдөлгөөн муудах, бие хөших, хэрэх, тулайн өвдөлт, тархины гэм, эрхтэний мэдрэхүй доройтох, хэл тультраадах, хэлгийрэх, халуун, хүйтэн цагаан судлын өвчнийг хоцролгүй дарна[9].

9. Алт:

Аль ч эрдэнийн эмийн аймгийн үест

Алт насыг уртатган, өтлийг чангалж, эрдэнийн хор арилгана. Ахиулаад мөнгө бээр шар усны өвчин хийгээд өгөр цус хатаана" хэмээх тэргүүтнийг зарлигласнаас алт (Aurum) нь шар өнгөт эрдэнэ бөлгөө. Ялгаваас, Замбү мөрний алт хийгээд энгийн алт болой. "Саран гэрэл" судрын бүлэгт: "Урт наст шувуу[5]-ны сангаснаас гарсан алт ялгамжтай ба загас бээр Замбү дриша ('dzambu trisha) мод идсэний сангас алт болсныг Замбү мөрний алт гэдэг. Шоргоолжны үүрний алт маш их улаан хийгээд Гарлог[6]-ийн алт өчүүхэн төдий улаан бөгөөд алтны мөн чанартай болой" хэмээжээ. Үүгээр насыг уртатган, хөгшдийг чийрэгжүүлж, эрдэнийн хорыг арилгана.(Зураг 9)



Зураг 9. Алт (Aurum)

10. Мөнгө: Мөнгө (Argentum)-ний цагаан, хөх хоёр нь хольцоогүй буй. Хүрэл нь мөнгө хүрэл лүгээ холилдсон хийгээд хаян хали (hayang hali) лугаа холилдсон тэргүүтэн гарсан ч бодитой хоёр нь сайн болой. Зэсэнд эр зэс, эм зэс, манин зэс, болор чулуу, цэнхэр хөх лүгээ тав болой. Тугалганд хар, цагаан хоёроос цагаан нь шөнө дэгдэн ууршаад, цагаан тугалга хийгээд хар нь тугалга ямагт болой. Тэр ч эрдэнийн үрлийн найрлаганд их, дунд, бага гурав буйн эрдэнийн энэ найрлагын оройн чимэг болсон тийн ялгуулсан арүр нь тэнгэрийн орноос гарсан хэмээн алдаршсан бөгөөд үүний хүч, их эрдмүүдийг өгүүлж баршгүй буй. "Тэжээхүйн намжал арүр эс ирвээс арүрийг хоёроор барилдуулах, гурваар барилдуулах, үзүүрийг төмөр гох мэт ирүүлэхүй хийгээд найман талаар ч их болох болой. Анагаах ухааны гол судраас гарсан нугуудыг өчүүхэн төдий өгүүлэхэд зургаан амт төгс, найман амт төгс, арван долоон эрдэм төгссөн, өвчний язгуур болсон нугуудыг арилгасан, сайн үнэрт, харваас үзэсгэлэнтэй, сэтгэлд зохистой, эмийн асуулт түгсэнд дөрвөн зуун дөрвөн өвчин эс гарахуй буй болой" хэмээсэн хийгээд тэр ямагтаас: "Тийн ялгуулсан хулууны сүүл мэт, хий, шар, бадган хурсан өвчнийг дармой. Ялангуяа өлзийт хэрэг бүхэн бүтсэн бээр сайн" хэмээн зарлигласан болой[10]. Мөнгөөр шар ус, өгөр цусыг хатаана. (Зураг 10)



Зураг 10. Мөнгө (Argentum)

Дүгнэлт: Дармо маарамба Лувсанчойдогийн "Сайн номлол цагаан лянхуан эрхи хэмээх оршвой" гар бичмэл судар нь олон эрдэнийн эмийн эх булгийг шинжлэх арга, эмийн гол судруудад байгаа эрдэнийн эмийг хялбар таних, ойлгуулах, тэдгээрийн ангилал, агуулга, нэр томьёог сайтар тайлбарласан улаан хөтөлбөр болсон бүтээл болох нь судалгаагаар тогтоогдов.

Төслийн нэр: Research on the Sorting and Utilization of the Ancient Mongolian Medical Literature "Bailiu li zhi man" Inner Mongolia Minzu University key Laboratory open fund (MDK 2022040)

Ном зүй:

1. *Qimuge, Тэрбиш Л, Болд Ш. Дорнын их оточ, Дармо маарамба Лувсанчойдогийн цадиг, түүхийг судлах асуудал. Монголын Анагаах Ухаан. УБ, 2019, No1 (187) p.60-64*
2. *Qimuge, Bold Sh. Дармо маарамба Лувсанчойдогийн намтар, бүтээлийн тухай мөчид өгүүлэх нь* 中国民族医药协会蒙医药专业委员会成立大会暨首届学术年会：探讨 "达日茂玛仁巴·罗布桑超日嘎"的自传与著作 *2018.8*
3. *Чимэг, Л.Тэрбиш, Ш.Болд, Төвөд үсэг бичгийн хэлбэр түүний ялгаа, онцлогийг тодруулах нь. Mongolian Journal of Integrated Medicine: Цуврал 1, Дугаар 1, 2019, p.74 -77*
4. *Чимэг, Л.Тэрбиш, Ш.Болд, Төвөд үсэг бичгийн хэлбэр түүний ялгаа, онцлогийг тодруулах нь. Mongolian Journal of Integrated Medicine: Цуврал 1, Дугаар 1, 2019, p.74 -77*
5. *Qimuge, Terbish L,Bold Sh. New Theoretical and Methodological Concept in Traditional Medicine. Монголын уламжлалт анагаах ухааны олон улсын эрдэм шинжилгээний их хурал, Улаанбаатар хот, Төрийн ордон, 2019 оны 06 сарын 20, p.180*
6. *"Рашааны зүрхэн найман гишүүнт нууц увдисын үндэс" (Орчуулсан Минжүүр гүүш). Модон барын монгол судар.*
7. *Тойн Жамбалдорж. Үзэсгэлэнт нүдэн чимэг. Модон барын төвөд судар.*
8. *Монголын уламжлалт анагаах ухааны эм найрлагын судлал. (Төслийн удирдагч Ш.Болд) УБ, 2014, х.279*
9. *Монголын уламжлалт анагаах ухааны эм найрлагын судлал. (Төслийн удирдагч Ш.Болд) УБ, 2014, х.282*
10. *Дармо маарамба Лувсанчойдог. Сайн номлол цагаан лянхуан эрхи хэмээх оршвой (legs bshad be ed'u dkarpo'i 'phreng ba zhes bya ba bzhugs so). Толгойгүй хорхой шар үсгээр бичсэн гар бичмэл судар.*

[5] Урт наст шувуу (སྤུ་རྩེ་རིང་གི) нь цагаан тогоруу, өл халзан тогорууны ёгт нэр

[6] Гарлог (གཏ་ལོག) 葛逻禄 Кашмыр орны Эртний Түрэгийн нэгэн угсаа, түүний хаан нь XI зууны үед Лха лам Иш Одыг хөнөөсөн билээ. Бас Зүүн хойт Төвөдөд нутаглах түрэг угсаат малчин овог аймаг

Explanation of precious medicines in the ancient medical books written by Maaramba Luvsanchoidog

Qimuge[1,3], Terbish L[2], Bold Sh[1]

[1]International School of Mongolian Medicine, MNUMS
[2]Mongolian National Academy of Sciences
[3]Mongolian Medical College, Inner Mongolian Minzu University
E-mail: bold@mnums.edu.mn, Tel: +976-99111418

Background: The medical works written by Darmo Maaramba Luvsanchoidog have been an important source for the theory, treatment, training, and research of traditional Mongolian medicine. In recent years, a number of his medical books written by dbu med (in English headless scriptures) have been found, but they are difficult to read or translate and have not been studied at all in Mongolia. Therefore, the study has been carried out to facilitate the use of handwriting medical scriptures by Darmo Maaramba Luvsanchoidog for research, teaching, and explaining complex words in his books.
Aim: Explain the difficult words related to precious medicines in the book called "legs bshad be ed'u dkar poi 'phreng ba zhes bya ba bzhugs so" written by Darmo Maaramba Luvsanchoidog.
Materials and Methods: Methods of textual analysis for ancient books and analysis and synthesis were used in the study.
Results: The composition of the precious medicine is unique in that it can stop the disease from the root and does not reactivate the disease more than other medicines. In addition, it is mainly used to cure dead-end diseases and relieve chronic diseases after being treated with other sedative ingredients. There is a wide range of medicinal properties of precious medicinal ingredients. In particular, ring srel (in English relic), which has long been forgotten in traditional medicine, has gained practical significance as it clearly explains its classification, nature, and use.
Conclusions: In the book "legs bshad be ed'u dkar poi 'phreng ba zhes bya ba bzhugs so" written by Darmo Maaramba Luvsanchoidog clearly outlines the method of analyzing the sources of many precious medicines. Furthermore, the research identified that "legs bshad be ed'u dkar poi 'phreng ba zhes bya ba bzhugs so" is a significant work to understand precious medicines in the main scriptures of medicine and thoroughly explain their content and terminology.

Keywords: Darmo maaramba, Handwriting, Medical scriptures, Precious medicines, Traditional medicine